

**“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2020 оны 09 дүгээр сарын
14-ний өдөр

№ ХХХ.03/03-1

Улаанбаатар
хот

**“Жуулчин Дюти фрий” ХК-ийн 2020 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн хувьцаа
эзэмшигчдийн ээлжит бус хурлын тэмдэглэл.**

2020 оны 09 сарын 14-ний өдөр 10:00 минут, Даваа гараг, Хан-Уул дүүргийн 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Таван Богд Группийн төв байрны, 2.5 дугаар давхрын хурлын танхимд хуралдав.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Сайн байцгаана уу. Хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн амар амгаланг эрье. Ингээд хурлын дэгийг та бүхэнд танилцуулъя.

Хурлын дэгийг танилцуулав.

Одоо хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн дагуу хурлын ирц бүртгэлийн талаар тооллогын комиссын дарга Т.Солонго танилцуулна.

Тооллогын комиссын дарга Т.Солонго: Сайн байцгаана уу. “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн танилцуулъя.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит энэ хуралд 2 хувьцаа эзэмшигч биеэр оролцож, нийт саналын эрх бүхий нийт хувьцааны 76,63 хувь болж байгааг хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигч нар болон хурлын даргад мэдээлсүгэй. Ингэснээр хурлыг хүчин төгөлдөрт тооцож хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг үргэлжлүүлэхэд ирц хүрсэн байна.

Хурлын ирцийн тогтоолыг танилцуулав.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Хурлын ирц хүчин төгөлдөр болсон байна. Тооллогын комиссоос тогтоол гарсантай та бүхэн танилцлаа. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар ТУЗ-ийн гишүүн Ч.Ванчин-Эрдэнийг томилсон боловч Хурлын дарга орон нутагт томилолттой байгаа тул хурлыг Гүйцэтгэх захирал Ё.Ганбат даргалуулахаар ТУЗ-ийн дарга шийдсэн байна.

Хурлын дэгийн дагуу компанийн үйл ажиллагааг танилцуулаад хурлаа эхэлье.

Хурлын дарга Ё.Ганбат: Сайн байцгаана уу та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая.

Тус компанийнд нэр дэвшсэн Ц.Баатарсайхан, Д.Хулан, Ц.Оргилболд, Ц.Оюунцэцэг, Ц.Цэцэнхүү, Ч.Ванчин-Эрдэнэ, хараат бус гишүүд Я.Пүрэвээ, Д.Байгальмаа, В.Хүрэлхад, Ч.Нанжидсамбуу нарын танилцуулгыг танилцуулж дууслаа.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Та бүхнээс ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчтэй холбоотой асууж тодруулах зүйл байна уу.

Байхгүй гэв.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Хурлын дэгийн дагуу хэлэлцэх асуудлыг хэлэлцэж дууслаа.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Хурлын дэгийн дагуу хэлэлцсэн асуудлын хүрээнд санал хураалт явуулна. Саналыг кумулятив аргаар тоолно. Саналын хуудасны доод хэсэгт саналын хуудас хэрхэн бөглөх зөвлөмж байгаа та бүхэн сайтар уншиж танилцан саналын хуудсаа алдаагүй бөглөнө үү. Алдаатай, засвартай бөглөсөн бол тооллогын комисст хандан дахин саналын хуудас авч бөглөх боломжтой.

Саналын хуудас болон санал хураалттай холбоотой асууж тодруулах зүйл байвал нээлттэй шүү.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Тооллогын комиссоос саналын дүнгээ нэгтгэн та бүхэнд танилцуулахад бэлэн болсон байна.

Тооллогын комиссын дарга Т.Солонго: Нийт өнөөдрийн хуралд 2 хувьцаа эзэмшигч оролцсоноос дараах ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгохоор дараах байдлаар шийдвэрлэсэн байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр нэр дэвшигчид

1. Ц.Баатарсайхан	51,355
2. Д.Хулан	50,355
3. Ч.Ванчин-Эрдэнэ	51,355
4. Ц.Оюунцэцэг	49,747
5. Ц.Цэцэнхүү	51,355
6. Ц.Оргилболд	46,355

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр нэр дэвшигчид

1. Я.Пүрэвээ	50,087
2. Д.Байгальмаа	46,355
3. В.Хүрэлхад	50,087
4. Ч.Нанжидсамбуу	3,732

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: “Жуулчин Дютти Фрий” ХК-ийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр бүхий нэр дэвшигчдэд өгсөн саналыг танилцуулав.

Хурлаар хэлэлцэх асуудлын хүрээнд хувьцаа эзэмшигч нар ТУЗ-ийн гишүүдийг сонгосон тул ТУЗ-ийн шинэ гишүүдийг томилох тогтоолын төслийг танилцуулан баталлаа.

Ингээд өнөөдрийн хурал өндөрлөж байна хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа. Хурлыг хааж үг хэлнэ үү хэмээн хурлын дарга Ё.Ганбатыг урьж байна.

Хурлын дарга Ё.Ганбат: “Жуулчин Дютти Фрий” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд хүрэлцэн ирж оролцсон, ТУЗ-ийн гишүүдээ сонгосон та бүхэнд баярлалаа та бүхний ажилд амжилт хүсэн энэ хориг маань хурдан нээгдээсэй гэж ерөөл дэвшүүлье ээ.

Хурлын дарга:



Ё.Ганбат

Тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Б.Бат-Эрдэнэ

2020 оны 09 сарын 14-ний өдрийн 10 цаг 50 минутад дуусав.